



**“ОРОН НУТГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН МАНЛАЙЛАЛ”  
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**1.Зорилго:**

Орон нутгийн удирдах ажилтнуудын манлайллыг идэвхжүүлэх, төрийн бодлого, шийдвэрийг танилцуулж хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэхэд сургалтын зорилго чиглэгдэнэ.

**2.Хамрах хүрээ, зохион байгуулалт:**

Сургалтад 21 аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар хамрагдана.

Сургалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газраас Удирдлагын академитай хамтран зохион байгуулна.

**3.Хугацаа, газар:**

- Сургалтын нийт хугацаа 2026 оны 06 дугаар сарын 24-25-ны өдрүүд.
- Бие даан судлах сургалтын хугацаа 2026 оны 06 дугаар сарын 24.
- Танхимын сургалт: Удирдлагын академийн Б байрны Их танхим. 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 09.00 цагт эхэлнэ.

**4.Сургалтын агуулга:**

Сургалтын агуулга нь нийт 16 цаг. Үүний 8 цаг нь бие даан судлах сэдэв бөгөөд Удирдлагын академиас бэлдсэн дараах сэдвийг судалсан байна.

№	Сэдэв, агуулга	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
1	Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, тайлагнал, түүний хяналт-шинжилгээ, үнэлгээ	2026.06.24	Аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нар	Удирдлагын академийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан агуулгыг судалсан байна.
2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт, үнэлгээ, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх	2026.06.24		
3	Бусад сэдвүүд	2026.06.24		

**5.Танхимын сургалтын агуулга, дараалал:**

2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Пүрэв гараг.

№	Сэдэв, агуулга	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
1	Бүртгэл	08.30-09.00	ЗГХЭГ-ОНУЗГ	
2	<b>Сургалтыг чиглүүлэгч:</b> ОНУЗГ-ын Засгийн газрын ахлах референт Э.Бат-Идэр	09.00-18.00	ЗГХЭГ-ОНУЗГ	
3	<b>Сургалтын нээлтийн үг:</b>	09.00-09.20	ЗГХЭГ-ОНУЗГ	

	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр /Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн/ -Удирдлагын академийн захирал доктор, профессор Д.Байгал		Удирдлагын академи	
4	-Дурсгалын зураг авахуулах -Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөх	09.20-09.40	ОНУЗГ- Засгийн газрын ахлах референт Б.Ундрал	
5	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учралаас санаачлан хэрэгжүүлж буй "Чөлөөлье" бодлого, түүний хэрэгжилт	09.40-10.30	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг	
6	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал	10.30-11.00	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга С.Батболд	
	Цайны завсарлага	11.00-11.20		Б байрны Үүдний танхим
7	Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд анхаарах асуудал	11.20-12.00	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын ахлах референт Д.Отгон	
8	Нутгийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоо, түүнд хийх чиг үүргийн шинжилгээнд хамтран ажиллах тухай	12.00-12.30	ЗГХЭГ-ын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга Т.Гантогтох	
9	Төрийн албан хаагчдын цалингийн тогтолцоо, шинэчлэлтийн асуудал	12.30-13.00	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа	
	Өдрийн хоол	13.00-14.00		Б байрны Үүдний танхим
	<b>Сургалтын чиглүүлэгч:</b> Удирдлагын академийн Судалгаа, эрдэм шинжилгээний албаны дарга, доктор, проф. Я.Бямбаяр	14.00-18.40	Удирдлагын академи	
10	Захиргааны шийдвэрт тавигдах эрх зүйн шаардлага: Анхаарах асуудал	14.00-16.00	Удирдлагын академийн багш, доктор, дэд проф. А.Алтанзул	
	Цайны завсарлага	16.00-16.20		Б байрны Үүдний танхим

11	Удирдлагын шийдвэрт хиймэл оюун ухаан ашиглах нь: Практик хэрэглээ	16.20-17.30	Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн захирал, доктор, дэд проф. Ж.Жаргал	
12	ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газраас өгөх мэдээлэл, зөвлөмж чиглэл	17.30-18.00	ОНУЗГ-ын Засгийн газрын ахлах референт Н.Хонгорзул	
13	Сургалтын үнэмлэх гардуулах	18.00-18.40	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн Удирдлагын академийн захирал доктор, профессор Д.Байгал	
14	<b>Хаалтын үг:</b> Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн	18.40-18.50	ОНУЗГ	
	Оройн хоол	18.50-20.00	ОНУЗГ-Засгийн газрын ахлах референт Э.Бат-Идэр	

### ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР